



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/588

Хэрлэн сум

Мотоцикл, мопедийн хөдөлгөөнийг түр  
хугацаагаар хориглох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зорчих хэсгийн гадаргуу цасаар хучигдсан халтиргаа гулгаа үүсэж, тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн нөхцөл байдал хүндэрсэн үед мотоциклоор замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт мотоциклтой замын хөдөлгөөнд оролцохыг 2022 оны 11 дүгээр сарын 21-ээс 2023 оны 4 дүгээр сарын 01-ийг дуустал түр хугацаагаар хязгаарласугай.

2.Хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, ард иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга сэрэмжлүүлэг өгч сурталчлах ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэж, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Батхүү), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3.Захирамжид тусгагдсан арга хэмжээний үр дүн, явц байдлыг Цагдаагийн газрын дарга, сумын Засаг дарга нарт танилцуулж, хойшид авах арга хэмжээний саналыг оруулж ажиллахыг сумдын Засаг дарга Цагдаагийн газрын дарга, (цагдаагийн хурандаа Д.Батхүү) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ